

## Баримтат мэдээлэл



# АНЭУ



### Туг

Эмиратын далбаа нь Абу Даби, Ажман, Дубай, Фужайра, Рас аль Хайма, Шаржа, Ум ал Хувайн зэрэг бие даасан долоон эмирт улсын нэгдэн нийлсэний билэгдэл бүхий өнгөтэй байдаг. Ногоон өнгө нь үржил шим, цагаан өнгө нь энх тайван, төвийг сахисан үзлийн билэгдэл юм. Хар нь нефтийн баялаг, улаан нь Харижит муслимчуудын урьдын тугны өнгө бөгөөд хүч чадал, эр зоригийг билэгдэнэ. Төрийн далбаа нь энэ үндэстний хамгийн чухал билэг тэмдгийн нэг бөгөөд ард түмэн тэдний бахархлыг билэгдэнэ.

### Арабын Нэгдсэн Эмирт Улс

АНЭУ-ыг Эмират гэж товчилж нэрлэх ба энэ улс Баруун Азийн Персийн буланд Арабын хойгийн зүүн өмнө хэсэгт оршино. Хуурай газраар Оман, Саудийн Арабтай хиллэх ба далайгаар Ирак, Кувейт, Бахрэйн, Катар, Ирантай хиллэдэг. АНЭУ нь 7 эмирт улсын холбооны улс ба эмирт улс тус бүрийг үе залгамжилсан шейх захирах боловч улсын ерөнхийлөгчтэй байдаг. Абу Даби, Ажман, Дубай, Фужайра, Рас аль Хайма, Шаржа, Ум ал Хувайн зэрэг 7 эмирт улстай. Нийслэл хот нь Абу Даби бөгөөд энэ хот нь тус улсын улс төр, аж үйлдвэр, соёлын төв юм. 1971 онд тусгаар тогтнохынхоо өмнө АНЭУ нь 19-р зууны үеийн тухайн орон нутгийн овог аймгуудын захирагч үе залгамжилсан шейхүүд болон Британий хооронд байгуулсан эвлэрлийн гэрээнээс үүдэн Эвлэрлийн улс буюу Эвлэрлийн Оман нэртэй байсан. 18-20-р зууны хооронд энэ улсын далайн боомтуудаас далайн дээрэмчид далайд гардаг байснаас үүдэн Эмиратыг Далайн дээрэмчдийн эрэг гэж ч нэрлэдэг байсан. 1971 оны Үндсэн хуулийн дагуу тус улсын улс төрийн тогтолцоо нь эрх баригч долоон субъектээс бүрдэнэ. 7 эмир нь өөр өөрийн нутагтаа хэмжээгүй эрх эдлэх боловч нийт Эмирт улсын төвшинд улсын Ерөнхийлөгчтэйгээ нийлээд үндсэн хуульт хаант улс бүгд найрамдах улсын холимог тогтолцоотой улс юм.

АНЭУ-ын албан ёсны шашин бол лалын шашинтай бөгөөд араб хэл албан ёсны хэл болдог. АНЭУ нефтийн нөөцөөрөө дэлхийд 6-д жагсах ба тус улс Баруун Азийн хамгийн өндөр хөгжсөн эдийн засагтай улс юм. Эдийн засгийн хүчин чадлын хувьд дэлхийд 35-д орж, нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүн нь жилд \$48,597 байх ба энэ үзүүлэлтээрээ дэлхийн хамгийн баян улсын тоонд орж байдаг. Нэг хүнд ногдох худалдан авах чадварын хувьд дэлхийд 15-д орох ба Хүний хөгжлийн индексээрээ Азидаа дээгүүр орж дэлхийд 30-д зогсдог. Олон улсын валютын сангийн үнэлэмжээр АНЭУ нь өндөр орлого бий болгодог эдийн засагтай улс гэсэн ангилалд орж байдаг.

## Бедуины уламжлалт соёл

Бедуинчууд нь дотроо овог аймагт хуваагддаг цөлийн нүүдэлчин арабчууд юм. Энэ үг нь беду буюу цөлийн хүн гэсэн араб үгнээс гаралтай бөгөөд арабын цөлийн нүүдэлчдийг хэлдэг үг юм.

Бедуины олон омгууд уламжлалт зан заншлаа хадгалан баянбүрдээс баянбүрдийн хооронд нүүдэллэж явдаг.

Хичнээн цөөхөн хүнтэй байсан ч нэг омгийн хүмүүсийг удаан хугацаагаар амьдарч малаа маллаж

болохуйц газар нутаг цөлд байхгүй учир бедуинчууд нэг газраас нөгөөд байнга нүүдэллэн амьдрах

болдог. Бедуинчууд хонь, ямаа, тэмээгээ маллан үржил шимтэй нэг газраас нөгөөд нүүдэллэн явах

ба тэдний орхиод явсан нутаг нь эргэж нүүдэллэн ирэхийг хүртэл нь байгалийнхаа жамаар нөхөн

сэргэж төлжиж байдаг. Бедуин хүнийг куфияаа гэх бөс даавуу, агал гэх ороолтоор ороож өмсдөг малгайгаар нь таньж болдог. Толгойны ороолтон малгай нь их утга учиртай бөгөөд тухайн этгээдийн зэрэг зиндаа үүрэг хариуцлагыг харуулж байдаг. Бедуин эмэгтэйчүүдийн малгай ч гэсэн тэдний нийгмийн байр суурийг харуулах ба эмэгтэйчүүд үсээ битүү халхалсан ороолт зүүж ялангуяа гэрлэсэн эмэгтэйчүүд асаба гэх духаа дарсан хар ороолт зүүдэг. Бедуин хүний булш их энгийн ба толгойн болон хөлний тус газар нь нэг нэг чулуу тавьсан байдаг. Мөн талийгаачийн булшин дээр нь өмсөж байсан хувцсыг нь тавих ёсон байх ба түүний хажуугаар явж өнгөрсөн аяны хүнд хэрэгтэй бол тэр хувцсыг нь авч хэрэглэг гэсэн уламжлал байдаг байна. Бедуин асар дотроо манад гэгдэх нэхмэл даавуу унжуулж хоёр хуваадаг. Нэгд нь эрчүүд болон зочдын хэсэг ба үүнийг магаад буюу суух газар гэнэ. Нөгөөг нь махарама буюу эмэгтэйчүүдийн тал ба энд эмэгтэйчүүд хоол ундаа хийж эмэгтэй зочдоо хүлээж авдаг. Бедуин хүн асартаа уригдсан зочноо ихэд хүндлэн дайлах ба шинэхэн өтгөн бөгөөд нэгэн зүйл ургамлаар амталсан кофе уулгадаг. Зочид ирэхэд ихэд баярлан найр хийж хөгжим тоглож, яруу найраг уншин бүжиг бүжин цэнгэх нь ч бий. Бедуин хөгжимчний уламжлалт зэмсэг нь шабба ба гэх нэгэн зүйл метал лимбэ, рабаба хэмээх нэг утастай хуур байдаг бөгөөд тэд сайхан хоолойтой дуучид байдаг.

## Шашин

Лалын шашин бол АНЭУ-ын албан ёсны шашин ба хүн амын 96 хувь нь лалын шашинтан ба

үүний 16 хувь нь шийт урсгалын муслимчууд юм. Үлдэх 4 хувь нь христос болон хиндучууд

байдаг. Энэ орон лалын шашинтай боловч бусад шашинг ч хүндлэн үзэх ба Дубай хотод Гэгээн

Мэригийн католик, Ариун Гурвалын гэсэн 2 ч христос сүм байдаг. Ихэнхи араб болон лалын

шашинтай хүний өдөр тутмын амьдрал нь ариун ном гэгдэх Куран хэмээх сударт заасан ёсоор

өнгөрч байдаг. Куран нь лалын ертөнцийн үндэс суурь бөгөөд лал шашинтай хүний хувийн

амьдралаас арилжаа наймааг хүртэл амьдралын бүхий л хэм хэмжээ ёс заншил, зарчмыг

тодорхойлсон цогц сургаалийг агуулсан байдаг гэнэ. Лал шашинтай хүн өдөр бүр ариун Мекка

хотын зүг харан өдөрт 5 удаа мөргөл үйлдэж байдаг. Өдөр тутмын мөргөлийг заавал сүмд хийх

албагүй. Лалын шашинтай хүн мөргөлийн цаг л болсон бол олон нийтийн газар ч байсан

хамгаагүй хаа бололцоотой газраа мөргөлөө хийдэг. АНЭУ даяар олон тооны лалын сүм буюу

моск байх ба мөргөлийн цагийн өмнө муэззин хэмээх зарлагч сүмийн оройгоос өдөрт 5 удаа

мөргөл болохын чангаар зарлан дуудаж байдаг. Баасан гараг бол ариун өдөр гэж үздэг.

АНЭУ-ын Үндсэн хуулийн дагуу хүн ёс заншлынхаа дагуу шашин шүтэх эс шүтэх эрхтэй ба

төрөөс энэ эрх чөлөөг ерөнхийдөө хүнлэх боловч үүнд тодорхой заасан хязгаарлалт бас байдаг.

Холбооны Үндсэн хуулиар лалын шашин бол албан ёсны шашин байдаг.

## Сувд түүх

<http://www.thenational.ae/news/uae-news/the-perils-of-the-pearl-divers#full> -ийг үзэх

<http://www.sheikhmohammed.co.ae/vgn-exttemplating/> --ийг үзэх

<v/index.jsp?vnextoid=b8e2a89a2aaa0210VgnVCM1000004d64a8c0RCRD&vnextchannel=2bec4c863>

1cb4110